


Баян-Олгий аймгийн мэргэжлийн хяналтын газрын санаачлагаар ходолморийн аюулгvй байдалтай холбоотой дугуй ширээний ярилцлага зохион байгууллаа.

Ярилцлагад холбогдох албан байгууллагууд болон vйлдвэр, аж ахуйн газруудын хариуцлагатнууд оролцож санал солилцлоо. Мэргэжлийн хяналтын байцаагчид болон нийгэм хамгааллын ажилтнууд асуудалд шvvмжлэлтэй хандлаа.

Барилгачид оорсдод нь олгогдсон ходолмор хамгааллын хувцас, хэрэгслийг тэр бvр хэрэглэдэггvй, нийгэм даатгалын шимтгэлийн оронд ходолморийн холс ахиухан авахыг хvсдэг байна. Цахилгаан эрчим хvчний байгууллагын нэг хvн онгорсон жил осолдож амь vрэгдэн, нэг хvн оорийн буруу ажиллагааны улмаас гэмтэл авсан зорчил гарсан байна.

Ноос угаах vйлдвэрт аюул осол нэн их гардаг тул энэ байгууллага ажилчин бvртэй ажилладаг, байнга сургалт хийж хичээл заадаг аргыг сонгосон байна. Уг vйлдвэр 400 гаруй ажилчинтай боловч ноосны vнэ ханш буурсанаар одоо 120 хvнтэй ажиллаж байгаа тухай «Аватекс-Кайнар» компанийн захирал С.Хидирпатша ярилаа.